



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 4/80

Улаанбаатар хот

Г Улаанбурхан өвчнөөс урьдчилан
сэргийлэх, хариу арга хэмжээг
эрчимжүүлэх тухай

Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.24, 35 дугаар зүйлийн 35.6 дэх хэсэг, Дархлаажуулалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5, 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Сайдын зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн хурлын 2 дугаар шийдвэр, Дархлаажуулалтын үндэсний зөвлөх хорооны 2023 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг “Улаанбурхан өвчнөөс хамтдаа сэргийлье” уриан дор 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрөөс 6 дугаар сарын 05-ны өдруүдэд зохион байгуулсугай.

2. Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлогоос хоцорсон 15 хүртэлх насын хүүхдийг нөхөн дархлаажуулах ажлыг эрчимжүүлж, хамралтад тандалт, эргэмж судалгаа хийж, хариу арга хэмжээг зохион байгуулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Ж.Байгалмаа), Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3. Улаанбурхан, улаануудын эсрэг нэмэлт дархлаажуулалтын бэлтгэл ажлыг эхлүүлэх, үйл ажиллагааг зохион байгуулах нэгдсэн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

4. Халдварт өвчний эрт сээрэмжлүүлэг, хариу арга хэмжээний тандалтын тогтолцоогоор мэдээлэгдэж байгаа цочмог халууралт цэврүүт болон толbon, гувдруут тууралттай хамшинжийн тохиолдолд судалгаа хийх, лабораторийн шинжилгээгээр оношийг баталгаажуулах, 7 хоног бүрийн эргэн мэдээлэлд тусган мэдээлж хэвшихийг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Ж.Байгалмаа)-д даалгасугай.

5. Нөхөн болон нэмэлт дархлаажуулалтын ач холбогдол, эрсдэлийн харилцаа холбоог идэвхжүүлж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг эрчимжүүлэхийг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (С.Өнөрсайхан), Халдварт өвчин судлалын үндэсний төв (Ж.Байгалмаа), Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.

6. Өндөр тунт А аминдэмийг 5 хүртэлх насын хүүхдэд халдварт хамгааллын дэглэмийг баримтлан витаминжуулах ажлыг эхлүүлэхийг Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.

7. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т даалгасугай.

САЙД С.ЧИНЗОРИГ

141223811

Эрүүл мэндийн сайдын 2023 оны
05 дугаар сарын 18-ны өдрийн
дугаар тушаалын хавсралт

**Улаанбуурхан, улаануудын эсрэг нэмэлт дархлаажуулалтын үйл ажиллагааг
зохион байгуулах нэгдсэн төлөвлөгөө**

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран ажиллах
Нэг. Зохион байгуулалт, бүртгэл, судалгаа				
1.1.	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаалаар батлагдсан “Халдварт өвчинтэй ТЭМЦЭХ, сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөө”-ний зорилт 2.3-т “Улаанбуурхан өвчин зөөвөрлөгдөн орж ирэхээс сэргийлэх арга хэмжээ авах үйл ажиллагааны чиглэл”-ийг хэрэгжүүлэх зорилгоор холбогдох яам, газрууд, Аймаг, Нийслэлийн Засаг даргын газрын дэргэдэх нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч дарга наарт улаанбуурхан-улаануудын эсрэг вакцинаар нэмэлт дархлаажуулалтыг 10 сараас 8 насны хүүхдүүдийг хамруулан зохион байгуулах асуудлаар холбогдох албан бичгийг төлөвлөн хүргүүлэх.	2023 оны 5 дугаар сарын 25-ны дотор	ЭМЯ	ХӨСҮТ
1.2	Улаанбуурхан, улаануудын эсрэг вакцинаар нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулах тухай сайдын тушаалын төсөл боловсруулж баттуулах.	2023 оны 5 дугаар сарын 29	ЭМЯ	ХӨСҮТ
1.3	Улаанбуурхан, улаануудын эсрэг вакцинаар нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулах тухай Аймаг, Нийслэлийн Засаг даргын тушаал гаргуулан хэрэгжүүлэх.	2023 оны 6 дугаар сар	Аймаг, Нийслэлийн ЭМГ	Аймаг, дүүргийн Засаг Дарга
1.4	Вакцины хулээн авах, хадгалах, түгээх үеийн хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах улаанбурхан, улаануудын эсрэг вакцин, маркер, дагалдах хэрэгслийг хүлээн авах.	2023 оны 5 дугаар сар	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ

1.5	Аймаг, нийслэлийн 10 сартайгаас 8 наасны хүүхдийг бүртгэж, тоо (эмзэг булагийн хүн ам, тур оршин суугч)-г нэтгэж хамрагдвал зохиц хүүхдийн тоог эцэслэн гарах.	Улаанбурхан, улаануудын эсрэг вакцинаар нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулах явуулын хөдөлгөөнт баг, дэмжлэгт хяналт хийх багийн бурэлдэхүүнийг томилж, нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан батлуулах.	2023 оны 5 дугаар сар	Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, бусад	ХӨСҮТ
1.6	Улаанбурхан, улаануудын эсрэг вакцинаар нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулах явуулын хөдөлгөөнт баг, дэмжлэгт хяналт хийх багийн бурэлдэхүүнийг томилж, нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан батлуулах.	2023 оны 5 дугаар сар	Аймаг, нийслэлийн ЭМГ	ХӨСҮТ	
1.7	Сургуулийн өмнөх боловсролын сургуулийн нэмэлт дархлаажуулалтад хамрагдах наасны хүүхдийн судалгааг гарах.	2023 оны 5 дугаар сарын 29-ний дотор	Аймаг, нийслэлийн ЭМГ	ХӨСҮТ	
1.8	Улаанбурхан, улаануудын эсрэг вакциныг батлагдсан хуваарийн дагуу аймаг, нийслэлэд хүргүүлэх	2023 оны 5 дугаар сар	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	
Хоёр. Нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулахад оролцох эмч, мэргэжилтийг сургах					
2.1	Нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулах, сургач багш бэлтгэх үндэсний сургалт зохион байгуулах.	2023 оны II улиралд	ЭМЯ, ХӨСҮТ	ДЭМБ, Аймаг, нийслэлийн ЭМГ, шшгэг, бхя, иНЕГ	
2.2	Бэлтгэгдсэн сургач багш нар аймаг, дүүрэг, сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн эмч, вакцинатор сувилагчийг оролцуулан сургалтыг орон нутагтаа зохион байгуулах.	2023 оны 5 дугаар сар	ДЭМБ, Аймаг, нийслэлийн ЭМГ	ЭМЯ, ХӨСҮТ	
2.3	Улаанбурхан, улаануудын эсрэг вакцинаар нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулах сувилагчийг нэмэлтээр бэлтгэх, сургалт зохион байгуулах (Цэргийн анти, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий газар (ШШГЕГ), Иргэний Нисэхийн Эмнэлгийн Алба)	2023 оны 6 дугаар сарын 05-ны дотор	ЭМЯ, ХӨСҮТ	ЭМХТ, БХЯ, ШШГЕГ	
2.4	Улаанбаатар хотын сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсрол, их дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн эмч, нийгмийн ажилтан нарыг сургаж бэлтгэх	2023 оны 5 дугаар сар	ЭМЯ, ХӨСҮТ, Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн байгууллага	ДЭМБ, БСШУЯ	
Гурав. Дархлаажуулах Үйл ажиллагаа					
3.1	Төрийн болон хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хуучдийг Улаанбурхан, улаануудын эсрэг вакцинаар дархлаажуулж, вакцин хийсэн тэмдэглэгээг зүүн гарын чигчий хуруун дээр хийх (явуулын хөдөлгөөнт баг)	2023 оны 5 дугаар сар	ХӨСҮТ, Аймаг, нийслэлийн ЭМГ	Тухайн байгууллагын удирдагууд	

3.2	Сургууль, цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдийг сүм, өрхийн эрүүл мэндийн төвөөр дамжуулан дархлаажуулах	2023 оны 5-6 дугаар сар	ХӨСҮТ	Аймаг, дүүрэг, сүм, хорооны засаг дарга, аймаг, дуургийн хорооны идэвхтэн
3.3	Нэмэлт дархлаажуулалтын хамралт, дархлаажуулалтын дараа гарч болох урвал хүндрэлийн Мэдээг дархлаажуулалтын нэгжээс өдөр бүр авах (хамрагдсан зорилтот бүлгийн хүн амын нэгдсэн бүртгэлийг дэлгэрэнгүй авах, мэдээллийн сан бурдүүлэх)	2023 оны 5-6 дугаар сар	ХӨСҮТ, Аймаг, нийслэлийн ЭМГ	Аймаг, нийслэлийн ЭМГ, бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд
Дөрөв. Мэдээлэл, сурталчилгаа				
4.1	Улаанбурхан, улаануудын эсрэг вакцины нэмэлт дархлаажуулалтын нээлтийн арга хэмжээг зарлах хэвлэлийн бага хурал зохион байгуулах (орон даяар хийх)	2023 оны 5 дугаар	НЭМҮТ, ХӨСҮТ	ДЭМБ, НҮБ-ЫН Хүүхдийн сан, НЭМХ, Аймаг, нийслэлийн ЭМГ
4.2	Нэмэлт дархлаажуулалтын талаар төлөвийн радио, олон нийтийн хэвлэл Мэдээллийн хэрэгслэээр өргөн сурталчлах (олны танил хумуусээр Мэдээллийг хүргүүлэх)	2023 оны 5-6 дугаар сар	НЭМҮТ, ХӨСҮТ	НҮБ-ЫН Хүүхдийн сан, НЭМХ, Аймаг, нийслэлийн ЭМГ
4.3	Олон нийтийн Мэдээллийн сүлжээг ашиглан нэмэлт дархлаажуулалтад хамрагдах тухай Мэдээллийг зорилтот бүлэгт хүргэх	2023 оны 5-6 дугаар сар	НЭМҮТ, ХӨСҮТ	НҮБ-ЫН Хүүхдийн сан, НЭМХ
4.4	Нэмэлт дархлаажуулалтын Мэдээллийг үүрэн холбооны хэрэглэгчдэд мессежээр илгээх	2023 оны 5-6 дугаар сар	НЭМҮТ, ХӨСҮТ	НҮБ-ЫН Хүүхдийн сан, Үүрэн холбооны операторууд
Тав. Дэмжлэгт хяналт, хамралтын түргэвчилсэн үнэлгээ				
5.1	Нэмэлт дархлаажуулалтын явцад дэмжлэгт хяналт хийх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд туслацаа үзүүлэх	2023 оны 5-6 дугаар сар	ЭМЯ, ХӨСҮТ	ДЭМБ, Аймаг, нийслэлийн ЭМГ
5.2	Сонгогдсон газруудад дархлаажуулалт хэрхэн явагдсаныг хамралтын түргэвчилсэн үнэлгэээр үнээр, шаардлагатай тохиолдолд нөхөн дархлаажуулах	2023 оны 6-7 дугаар сар	ЭМЯ, ХӨСҮТ	ДЭМБ, Аймаг, нийслэлийн ЭМГ
5.3	Нэмэлт дархлаажуулалтын үйл ажиллагааны нэгдсэн тайланг бичиж холбогдох газруудад хүргүүлэх	2023 оны 7 дугаар сар	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ